


ХХСан: 2023 оны 9 дүгээр сарын 01-ны байдлаар 2 зээлдэгч 19,8 сая төгрөгний зээлээ бүрэн төлж барагдуулан 11 зээлдэгч 10,4 сая төгрөг төлж нийт 30,2 сая төгрөгний эргэн төлөлтийг төвлөрүүлж төлөвлөгөөний дагуу 218,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 139,8 сая төгрөг төвлөрүүлж 64,1 хувийн эргэн төлөлттэй бөгөөд дансанд нийт 262,7 сая төгрөг төвлөрөөд байна.

Мөн 2022 онд төсөл хэрэгжүүлэхээр санхүүжилт авсан 3 аж ахуйн нэгж, 1 хоршоо, 1 иргэний үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаа Уг шалгалтаар гахайн аж ахуй болон бүх төрлийн төмөр хийцийн үйлдвэрлэл, даацын блок чиглэлээр төсөл хэрэгжүүлэхээр авсан аж ахуйн нэгжүүд тоног төхөөрөмжөө авч үйл ажиллагаагаа эхлүүлэн бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж эхлэсэн бөгөөд байнгын 11 ажлын байр, түр 29 ажлын байр нэмэгдүүлээд байна.

/ даацын блок /



/ гахайн аж ахуй /



Харин даацын блок чиглэлээр төсөл хэрэгжүүлэхээр санхүүжилт авсан 1 иргэний ажлын байраа засварласан, төсөл дээр тусгагдсан тоног төхөөрөмжөө аваагүй, Өвлийн хүлэмжээр төсөл хэрэгжүүлэхээр санхүүжилт авсан 1 аж ахуйн нэгж үйл ажиллагаагаа эхлүүлээгүй зэрэг зөрчил илэрсэн тул зөрчлийг арилгуулахаар Засаг даргын хугацаатай албан мэдэгдэх хуудас өгсөн.